

#### 4 САРЫН 22 ХҮРТЭЛ НИЙТЭД ХААЛТТАЙ

#### 2007 ОНЫ ГОЛДМАНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ШАГНАЛД АЗИАС ШАЛГАРАГЧ

#### **Ц. Мөнхбаяр**

Монгол Улс, Улаанбаатар хот

“Мөнхбаяр нь иргэний нийгмийн манлайлагч болон өсөн гарч ирсэн хүн. Тэрээр Монголд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалахад сэтгэл, хүчээ зориулсан иргэдийн хамгийн хүчтэй, өргөн тархсан хөдөлгөөнүүдийг нэгтгэхэд чухал үүргийг гүйцэтгэсэн юм. Мөнхбаяр чадварлаг бөгөөд чин сэтгэлээсээ ажилладаг. Энэ хослол нь түүний хувийн болон хамт олных нь өмнөө тавьсан зорилгод хүрэхэд гол түлхэц болсон.”

- Айванхоу Маинс Монгол Компанийн Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Лайтон Крофт

#### **Усны эх үүсвэрийг хамгаалах талаар**

Монголын өргөн уудам, хүн ам нь сийрэг суурьшдаг тал нутагт хуучирсан аргаар, зохицуулалтгүй уул уурхайн ажил эрхэлж байгаа явдал нь уг газар нутгийн гол мөрөнд ихээхэн аюул занал учруулж байгаа билээ. Хүн амын ихэнхи нь ядуу, хөдөө нутагт хагас нүүдэлчний ахуйгаар амьдардаг Монголын хувьд нэгэн хурц асуудал тулгараад байгаа нь: нэг талаас олон улсын зах зээлд өөрийн эх үүсвэрийг гаргах, нөгөө талаас хүнд нөхцөлд амьдарч байгаа ард иргэдийнх нь амьжиргааг тэтгэдэг байгаль орчныг хамгаалах зорилготойгоор холбогдох салбарыг хөгжүүлэх явдал юм. Энэ хүнд асуудлыг шийдвэрлэхэд сэтгэл хоёрдолгүйгээр шулуудан орсон Ц.Мөнхбаяр нь зохицуулалтгүй уул уурхайн аюулаас Монголын хамгийн үнэт эрдэнэ болох ус мөрнийг хамгаалах үйлсийг манлайлан ажиллаж байна.

Хөдөө нутагт амьдардаг Монголчууд ундны ус болон малынхаа усалгааны хэрэгцээний дийлэнхийг гол горхиносоо хангадаг билээ. Өнөөдрийн байдлаар ашигт малтмал олборлолтын хамгийн хоцрогдсон технологи болох өндөр даралтын ус шахах системээр ажилладаг зохицуулалтгүй уул уурхайн ажиллагаанаас болж Онги гол (Монголын хамгийн томд ордог голуудын нэг)-ын 30 гаруй салаа хатаж ширгээд байна. Угаасаа ус ховор Монголд усны эх үүсвэрийг ийнхүү сүйтгэж байгаа нь маш их сөрөг үр дагавартай билээ.

Мөнхбаяр нь малчны гэр бүлд төрсөн бөгөөд одоогийн байдлаар Онги голыг хамгаалж, сэргээх зорилгоор анх 2001 онд өөрийн гар бие оролцон байгуулалцсан олон нийтийн үүсгэл санаачилгын байгууллага болох “Онги Голынхон Хөдөлгөөн” (ОГХ)-ийг удирдан ажиллаж байна. Түүний энэ ажиллагаа өргөжин тэлж

Монголын байгаль орчныг хамгаалах эвсэл байгуулагдахад хүргэсэн бөгөөд одоо энэ эвсэл нь Монголын гол усаа хамгаалах 11 хөдөлгөөнийг нэгтгэж холбогдох асуудлыг олон нийт болон хууль тогтоогчдын анхаарал татах хэмжээнд хүргэхэд маш чухал үүрэг гүйцэтгэж байна.

### **Жирийн малчнаас олон нийтийн зүтгэлтэн**

Мөнхбаяр жирийн малчны хувьд 1990-ээд оны эхнээс орн нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд оролцож эхлэн ус, бэлчээр ашиглалт, татварын зэрэг асуудлаар нутаг усныхаа иргэдийн дуу хоолойг төлөөлөх болсон. Үүний үр дүнд 1996 онд түүнийг сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд, 2000 онд аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгосон нь жирийн малчны хувьд тун ховор тохиолдол байлаа. Сумын хурлын дарга, улмаар аймгийн хурлын төлөөлөгчийн хувьд тэрээр олон нийтийн эрх ашгийн төлөө дээд шатны удирдлага, төрийн түшээдтэй тулан ажиллаж байв. Тэрээр ялангуяа Онги гол ширгэж байгаа явдалд ихээхэн санаа зовон улмаар нутгийн иргэдийн дэмжлэгтэйгээр уул уурхайн хөнөөлтэй ажиллагааг зогсоож чадсан юм.

Мөнхбаяр гол усаа хамгаалах, сэргээхэд жирийн иргэдийн оруулах хувь нэмэр, хүчин чадалд итгэдэг. Тийм ч учраас тэрээр иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, байгалийн нөөцийг хамгаалах шаардлагад анхаарлаа хандуулан ажилладаг байна. Үүнтэй холбоотойгоор Мөнхбаяр малчдад зориулж иргэний эрх, байгаль орчны холбогдолтой асуудлаар семинар, сургалт зохион байгуулж байна. Түүнийг энэ ажилд хүчин зүтгэхээс өмнө нутгийн иргэд байгаль орчныг хамгаалах талаар хангалттай мэдлэггүй, өөрсдийн ашиг сонирхлыг бусдад даатгасан байдалтай байв. Ялангуяа төрийн түшээдийн авилгад автсан байдал, төрийн бодлого тодорхойлоход жирийн иргэдийн оролцох боломж хязгаарлагдмал байгаа нь байгаль орчныг хамгаалах түүний хүчин зүтгэлд ихээхэн хүндрэл учруулж байв.

Гэвч тавхан жилийн дотор Мөнхбаяр болон ОГХ нь Онги голын ай савын 3 аймгийн 8 суманд салбараа байгуулж, 4000 орчим дэмжигч гишүүдийг бүртгэн орон нутгийн иргэдийн үүсгэл санаачилгаар Монгол орны 14 аймагт байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүд байгуулагдан эвсэл болон нэгдэхэд гол үүрэг гүйцэтгэсэн байна. Өнөөг хүртэл тэрээр мэдээлэл түгээх, хэвлэл мэдээллийн ярилцлага, иргэдийн нээлттэй хурал хийх, Онги голын дагуу 470 км-ийн эсэргүүцлийн явган марш зохион байгуулах, экологийн сурах бичиг боловсруулан дунд сургуулийн хөтөлбөрт оруулах, голын эргийн дагуу ойн төгөл байгуулах, мэргэжлийн байгууллага, орон нутгийн удирдлага, малчидтай хамтран Онги голын ай сав газарт хур тунадас нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг хийгээд байна.

### **Монголд хариуцлагагүй уул уурхайн орон зай байхгүй**

ЗХУ задран унаж хуучин Зөвлөлтийн холбооны улсууд чөлөөт зэх зээлийн эдийн засагт хошууран ороод байсан үеэс Мөнхбаяр гол мөрнөө даган амьдардаг малчин ардынхаа өмнөөс болон өвөг дээдсийнхээ хэдэн зуун жилээр амьдарч ирсэн газар нутгаа хайрлах үүднээс гол горхины ус ширгэж байгаа явдалд улам ихээр санаа

зовних болсон юм. Учир нь чухам энэ үеэс эхлэн алт олборлолтын үйл ажиллагаа хүчээ авч зөвхөн Онги гол дагаж 30 гаруй компанид алт олборлох тусгай зөвшөөрөл олгогдоод байв. Ийнхүү зохисгүй, хууль бус олборлолт, хуулийн хэрэгжилт сул байгаа явдал Монгол даяар байгаль орчин, түүний нөөцийг эрчтэйгээр сүйтгэхэд хүргээд байна.

Энэ шалтгааны улмаас Мөнхбаяр өөрийнхөө бүх цаг хүчийг ОГХ-ний үйлсэд зориулан уул уурхайн салбарын зохицуулалтыг өргөжүүлэх, хуулийн хэрэгжилтийг чангатгах болон хор хохирол ихтэй уул уурхайг хаах, байгаль орчныг нөхөн сэргээхийн ач холбогдлыг төрийн зохих байгууллагуудад хүргэж байна.

2006 оны 5 сард Монгол Улсын Их Хурлаас Ашигт Малтмалын шинэ хууль баталсан бөгөөд үүгээр уул уурхайн зохицуулалтыг өргөжүүлэн тогтоож, гол мөрөнг хамгаалах заалтуудыг оруулжээ. Үүнээс гадна, Онги голын савд үйл ажиллагаа явуулж байсан 37 уул уурхайгаас 35 нь үйл ажиллагаагаа зогсоожээ. Түүнчлэн 2006 онд уг голын дагуу ажиллаж байсан Эрлийн уурхай (хамгийн их хөнөөлтэй) болон бусад 11 уурхай үйл ажиллагаагаа зогсоож Онгийн гол сүүлийн 8 жилд анх удаа 430 км урсаж, Улаан нуурт 7 км дөхөн очсон байна.

###

**Шагналтны ишлэл үг:**

Ц. Мөнхбаяр

Бид хүн төрөлхтөний ёроолгүй хэрэгцээнд байгаль ээжийнхээ хувь заяаг захируулж болохгүй. Эцсийн дүндээ энэ чинь бидний л хувь заяа шүү дээ.

***Голдманы Байгаль Орчны Шагнал***

*Голдманы Байгаль Орчны Шагнал нь байгаль орчныг хамгаалах хүнд хүчир замыг сөрөн ялалт байгуулах явдлыг урамшуулан, дэлхийгээ аврахад онцгой гавьяа байгуулсан жирийн иргэдэд урам зориг хайрлах зорилготой олгогддог. Энэ шагналыг иргэний манлайлагч, сайн дурын зүтгэлтэн Ричард Н. Голдман болон түүний эхнэр агсан Рода Голдман нар 1990 онд бий болгосон юм.*

*Голдманы Байгаль Орчны Шагналтнуудыг дэлхий даяар байгаль орчны салбарт ажилладаг байгууллага, хүмүүсийн зүгээс нууцаар нэр дэвшүүлж, олон улсын шүүгчдийн санал хураалтаар шалгаруулдаг. Шагнал авагсад нь шагнал гардуулах ёслолын ажиллагаанд оролцох, илтгэл тавих, хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөх, нийтлүүлэх, улс төр, нийгмийн бодлого боловсруулагчид, байгаль орчны салбарын төлөөлөгчидтэй уулзах зорилгоор Сан Франциско болон Вашингтон дүүрэгт 10 хоногийн хөтөлбөртэй ажиллана.*